


"Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-н
2023 оны 12 дугаар сарын 21 өдрийн
1159 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ӨНДӨРТ АЖИЛЛАХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. ЗОРИЛГО

1.1 Энэхүү журмаар "Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ (цаашид "ажил олгогч" гэх)-н эрсдэлтэй ажлын байр буюу өндөрт ажиллаж буй ажилтан болон тоног төхөөрөмжийг эрсдэлд оруулахгүй аюулгүй ажиллуулах, гарч болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хангаж ажиллана.

1.2 Журмыг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хүрээнд боловсруулсан бөгөөд журамд заагдаагүй асуудлуудыг эрхзүйн үндсэн баримт бичгийн дагуу шийдвэрлэнэ.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Энэхүү журмаар "Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-ын ажлын талбай нэг бүрд 1,5 метрээс дээш, доош өндөрт хийгдэх ажил болон антен, фидерийн байгууламж, цамхаг дээр суурилуулалт хийх, гэмтэл сааталд ажиллах, хэмжилт хийх эрх бүхий инженер, техникийн ажилтнуудын баримтлан ажиллах зарчим, үе шат, техник ажиллагаа болон хөдөлмөр аюулгүй ажиллагааны тоноглол, төхөөрөмжид тавих ерөнхий шаардлагыг тогтоож, ослоос урьдчилан сэргийлэх, аваар осолгүй орчин бүрдүүлж ажиллахад оршино.

ГУРАВ. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

3.1 "Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-ын өндөрт ажиллах эрх бүхий инженер техникийн ажилчид энэхүү журмын хориглох заалт, зааварчилгааг зөрчсөн тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон, байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу хариуцлага тооцно.

ДӨРӨВ. ЖУРАМ

4.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны журмыг "Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-ын 1.5 метрээс

дээш өндөрт ажил гүйцэтгэх шаардлага бүхий инженер, техникийн ажилтан албан хаагчид дагаж мөрдөнө.

4.2 Антен, фидерийн байгууламж, цамхаг дээр үзлэг үйлчилгээ, завсар хийх инженер техникийн ажилтан нь 18 нас хүрсэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны сургалтуудад сууж шалгалтад тэнцсэн, эрх бүхий үнэмлэхтэй, өндөрт ажиллахад нэгээс дээш жилийн ажлын дадлагатай, сүүлийн 12 сарын хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж тэнцсэн, ажлын байрны зааварчилга авсан инженер, техникийн ажилтанд ажил гүйцэтгэхийг зөвшөөрнө.

4.3 Анх удаа ажиллахаар томилогдсон хүн нь нэг жилийн турш удирдлагаас томилогдсон ажилтны хяналтад ажиллана. Өндөрт ажиллаж эхлэхээс өмнө инженер, техникийн ажилтан нь тохиолдож болох эрсдэлийг үнэлж, зохих хяналтыг хэрэгжүүлнэ.

ТАВ. ӨНДӨРТ АЖИЛЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

5.1 Өндрийн ажил гүйцэтгэж эхлэхийн өмнө ажилтан нь хариуцсан хэсгийн дарга болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженерт өөрийн эрүүл мэндийн ерөнхий байдал, цусны даралт, согтууруулах ба мансууруулах бодис хэрэглэсэн эсэх талаар шалгуулан, аюулгүй ажиллах зааварчилгаа авснаар ажиллах зөвшөөрлийг олгоно.

5.2 Ажил эхлэхийн өмнө эрх бүхий инженер, техникийн ажилтан нь нарядтай заавал танилцаж, зөвшөөрсөн тохиолдолд 2 тал гарын үсэг зурж баталгаажуулна. /хавсралт -2 хувь наряд /

5.3 Өндөрт ажиллах зөвшөөрөл авсан эрх бүхий инженер, техникийн ажилтан нарядан дээр заасан маягтын дагуу ажил гүйцэтгэсний дараа ажил дуусаж, бууж ирсэн цаг болон үргэлжилсэн цагийг бичиж маягтыг бөглөж хийсэн ажлаа хүлээлгэн өгч нарядыг хаалгаснаар ажил дуусгавар болно.

ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТАН

6.1 Антен, фидерийн байгууламж, цамхаг дээр үзлэг үйлчилгээ, завсар хийх, инженер, техникийн ажилтан нь 18 нас хүрсэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны сургалтуудад сууж шалгалтад тэнцсэн, эрх бүхий үнэмлэхтэй, өндөрт ажиллахад нэгээс дээш жилийн ажлын

дадлагатай, сүүлийн 12 сарын хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж тэнцсэн, ажлын байрны зааварчилгаа авсан байна.

6.2 Анх удаа ажиллахаар томилогдсон ажилтан нэг жилийн турш удирдлагаас томилогдсон ажилтны хяналтад ажиллана. Өндөрт ажиллаж эхлэхээс өмнө инженер, техникийн ажилтан нь тохиолдож болох эрсдэлийг үнэлж, зохих хяналтыг хэрэгжүүлнэ.

6.3 Өндөрт ажиллах зөвшөөрөл эзэмших, олгох эрхийн сургалтад 3 жил тутамд хамрагдаж байх ёстой.

6.4 Ажлын болон хамгаалах хувцас, хэрэгслийг батлагдсан нормын дагуу ажил олгогчоос олгоно. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг баталж мөрдүүлнэ.

6.5 Өндрийн ажил гүйцэтгэх эрх бүхий инженер, техникийн ажилтан нь хөдөлмөр аюулгүй ажиллагааны нийтлэг шаардлага хангасан, цаг агаарын нөхцөлд байдалд нийцсэн, тод өнгөтэй, гэрэлтсэн ялгарах тэмдэглэгээ бүхий ажлын хувцастай байна.

6.6 Өндрийн инженер, техникийн ажилтан нарын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн нормын хувцас, хамгаалах хэрэгсэл

- Ажлын хувцас /өвөл, зуны/
- Гутал,
- Бээлий
- Өндрийн бүс
- Татлага олс
- Каск /дуулга/
- Дөрөө

6.7 Өндрийн ажил гүйцэтгэхийн өмнө инженер, техникийн ажилтан нь хамгаалалтын хувцас хэрэгслийг бүрэн өмсөж, хамгаалах хэрэгслийг шалгах хуудасны дагуу /Хавсралт-1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шалгах хуудас/ шалгаж бүрэн бүтэн байгаа тохиолдолд гарын үсэг зурж баталгаажуулан хэрэглэнэ.

ДОЛОО. ӨНДӨРТ АЖИЛЛАХАД АЮУЛТАЙ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД

7.1 Бүдрэх, халтирах, унах

- Дээвэр болон барилга байгууламжийн завсар, нүх, ан цав
- Ажлын байрны эмх цэгцгүй байдал, замбараагүй хаягдсан хог, материал, цахилгааны утас
- Нойтон, халтиргаатай гадарга.
- Цаг агаар муудах цас, бороо, шуурга гэх мэт
- Доголдолтой, тогтворгүй тоноглол, хэрэгсэл /шат, сунадаг шат, тавцан, өргөгч/
- Тохиромжгүй гутал, халтирах ултай гутал

7.2 Цахилгаанд цохиулах

- Өндөр хүчдэлийн шугамд хүрэх .
- Үйлдвэрийн доголдолтой цахилгаан төхөөрөмж .

7.3 Дээрээс юм унах

- Хамгаалалтгүй задгай орхисон сэлбэг, багаж, төхөөрөмж
- Сул муу хамгаалттай материал
- Хангалтгүй бэхэлсэн ачаа, хийц бүтээц
- Хангалтгүй, тодорхойгүй, ирмэггүй хамгаалалтын хэрэгсэл.

7.4 Бусад ноцтой аюул осол

- **Цахилгааны аюул**– гагнуурын аппарат, бусад цахилгаан төхөөрөмж, кабель утас, уртасгагч, цахилгаан тасалдал гэх мэт цахилгаан багажууд.
- **Хүндийн** – бүдрэх, халтирах, унах гэх мэт юм унах.
- **Гар ажиллагаанаас үүсэх аюул** – Инженер, техникийн ажилтны ажиллагаанаас хамаарсан
- **Дулааны аюул** – халуун уур, ус болон цаг агаарын нөхцөлөөс хамаарч үүсэж болзошгүй.
- **Цацраг** – Нарны болон хэт ягаан туяаны
- **Ажиллах орчны аюул** – чийглэг, тоостой нөхцөл, гэрэл муутай, харагдац багатай орчин .

НАЙМ. АЖИЛД БЭЛТГЭХ

8.1 Цамхаг, антен фидерт өндрийн ажил гүйцэтгэхийн өмнө ажиллах орчны аюулгүйн хэмжилтийг хийж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг

ажил гүйцэтгүүлэх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер заавал шалгана.

8.2 Цамхагт болон антенд ажиллах үеийн бэлтгэл ажлын хүрээнд ажиллагааны үед хэрэглэх тусгай ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслүүдийг (каска дуулга, ажлын хувцас, бээлий, хамгаалах нүдний шил) журмын дагуу шалгаж бүрэн, зөв өмсөж хэрэглэнэ.

8.3 Антен, цамхагт авирах, буух, цамхаг дээр ажиллахад аюулгүй ажиллагааны шаардлагатай тэмдэг тэмдэглэгээг бүрэн, зөв байрлуулна.

8.4 Үүрэн холбооны антен, цамхгийн суурь, хамгаалалтын зурваст аюулгүй байдлыг хангаж, ажлын байрны эмх цэгц, ажиллагааны нарийн дэг журмыг тогтоон мөрдөж хэвшүүлсэн байна.

8.5 Эрх бүхий инженер, техникийн ажилтны ажлын байранд ажиллах заавар, санамж, хориглох хаалт, хамгаалалт, дохио анхааруулга байрлуулан тавих ба эдгээр нь зөөврийн болон байнгын байна.

8.6 Өндөрт ажил гүйцэтгэж байгаа өндрийн байгууламжийн хүрээлэлд хүн байхад аюултай орчныг антен цамхгийн өндрийн 1/3 зайг аюултай орчин гэж үзнэ. Харагдахуйцаар байрлалд өндрийн санамж тэмдгүүдийг тавьж байрлуулна.

ЕС. ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

9.1 Хэрэв эрсдэлийн үнэлгээ нь өндөрт ажил гүйцэтгэхтэй холбогдон бий болсон эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлж байгаа бол тухайн эрсдэлийг арилгах ба боломжгүй бол зохих эрсдэлийн хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлснээр багасгах хэрэгтэй. Тухайн ажлыг хийх зөвшөөрөл олгохгүй ба зөвшөөрөл олгогдсон бол яаралтай цуцална.

АРВАН. АЮУЛЫН ХЯНАЛТ

10.1 Хяналтын зарчмыг ажлын байрны аюулгүй байдлыг хангахад нэг болон хэд хэдэн хяналтыг сонгож ашиглаж болно. Хяналтын зарчим нь ажлын байрны аюулгүй байдлыг хангах ба дараах арга барилын жагсаалтыг агуулна. Энэхүү жагсаалт нь тухайн нөхцөл дэх хамгааллын их, бага, сүүлийн үр дүн дэх хамгийн их үр дүнтэй утгыг харуулдаг.

- **Арилгах:** Өндрөөс унаж болохуйц нөхцөлийг арилгаж, аюулыг арилгах хүртэл ажлыг зогсоох, орцыг хаах арилгах гэх мэт унах эрсдэлтэй орчныг ашиглах шаардлагыг хангах
- **Инженерчлэлийн аргачлал, тусгаарлах, салгах:** Унах эрсдэлийг үүсэхгүй байхаар хаалт хашилт хийх, унах нөхцөл үүсгэж болох шат тавцанг хааж хамгаална.

10.2 Удирдлагын хяналт: Удирдлагын хяналт нь эрсдэлийг хянахад чиглэгдэнэ.

Жишээ нь:

- Аюултай нөхцөл байдлын хамгаалалтыг тодорхойлсон, ажлын аюулгүй арга барилын зааварчилгааг хангасан ажил гүйцэтгэх зөвшөөрлийг хянах.
- Ажил үүргийн гүйцэтгэлийг хянах, осол аваараас сэргийлэх арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд авран туслах ажилтныг томилох.
- Ажиллагсдад ур чадвар олгох сургалт зохион байгуулах.

АРВАН НЭГ. ОРЧНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД

11.1 Гадаа орчны температур нь хүн ажиллахыг зөвшөөрөх буюу хязгаар -30–аас +30 хэм байх.

11.2 Салхины хурд 12 м/сек-ээс илүүгүй байх.

11.3 Цамхагт авирахад гулгалт, халтиргаа, мөстөлт үүсээгүй байх.

11.4 Бороо, цас ороогүй байх ба харанхуй, гэрэлтүүлэг муу бол ажиллахгүй байх цаг уурын газраас цаг агаарын мэдээг 2 цаг тутамд авч байна./Эрх бүхий байгууллагаас цаг уурын онцгой нөхцөл зарлагдаагүй байх./

11.5 Цамхгаас үзэгдэх орчин хязгаарлагдаагүй байх.

АРВАН ХОЁР. ХОРИГЛОХ ЗААЛТ

12.1 Өндөрт ажиллах инженер, техникийн ажилтан нь аянга цахилгаантай, 12 м/с-ийн хүчтэй салхитай, цас бороо, мөндөр орсон болон мөстөлттэй ширүүн бороо, цас орж буй үед болон мөн цамхгийн суурь хазайсан, татуурга тасарсан, хамгаалах шатны гагнаас салсан, байрны дээвэрт мөстөлт гулгаа үүссэн, үзэгдэх орчин хязгаарлагдсан зэрэг нөхцөлд антен, цамхагт гарч авирах, ажиллахыг хориглоно.

12.2 Нарядгүй /Зөвшөөрөл/ өндрийн ажил гүйцэтгэхийг хориглоно.

12.3 Өндрөөс эд зүйлс унагаах, багаж хэрэгслийг антен цамхгийн хийц дээр үлдээхийг хориглоно.

12.4 Гулсаж ирж буй эд зүйлийн холбоосыг гараар буюу хавчаараар барьж зогсоохыг хориглох ба нэн даруй буулгах дохио өгөх, үүний дараа холбоосыг засварлана.

12.5 Дамжих зориулалтгүй хийцээр явахыг хориглоно.

12.6 Өгсөх үед хэт хүнд ачаа өргөхийг хориглоно.

12.7 Алх ломбоор канатын холбоосыг чиглүүлэхийг хориглоно.

12.8 Люлькэнд байрлахдаа гагнуурын ажил гүйцэтгэх зэргийг хориглоно.

АРВАН ГУРАВ. ОСЛЫН ҮЕД ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙГ ХАНГАХ

13.1 Аюултай байдал үүссэн тохиолдолд өөрийн болон бусдын эрүүл мэндэд аюултай нөхцөлд ажлыг даруй зогсоох, бусдад мэдэгдэх, тоног төхөөрөмжийг салгах, аюултай бүсийг орхин холдох, шууд удирдлагадаа мэдэгдэх зэргийг даруй хийнэ.

13.2 Ослын үед сэргээх ажиллагааг нарядгүйгээр гүйцэтгэж эхэлж болох ба хойшлуулшгүй хийгдэх 1 цаг дотор хийж болох ажлыг даалгавраар гүйцэтгэж болно. Бүх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг авна.

13.3 Гал гарсан тохиолдолд шууд удирдлагадаа даруй мэдэгдэж галыг унтраах арга хэмжээ авч эхэлнэ. Унтраах ажлыг удирдаж зааварчилгаа өгч буй

хүний удирдлагын дагуу хийнэ. Ослын үед гэмтсэн ажилтныг гэмтэл учруулсан эд зүйлсээс даруй чөлөөлж, анхны тусламж үзүүлэх ба удирдлагадаа мэдэгдэнэ.

АРВАН ДӨРӨВ. АЖИЛ ДУУССАНЫ ДАРААХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

14.1 Ажлын байрны эмх цэгцийг шалгаж, багаж хэрэгслийг зориулалтын байранд тавина.

14.2 Ээлжийн ашиглалтын журналд зохих тэмдэглэгээг хийнэ.

14.3 Ажил гүйцэтгэх үед гарсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд нөлөөлөх зөрчлийг удирдлагад илтгэнэ.

14.4 Ажлын хувцсыг тайлж, зориулалтын байранд тавина.

---ooOoo---

"Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-н
2023 оны 12 дугаар сарын 21 өдрийн
11/59 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ӨНДӨРТ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ

НАРЯД № 001-00370

20.....оны сарынөдөр

Байгууллага, нэгжийн нэр

Наряд олгосон байгууллага нэгжийн дарга

/овог нэр, албан тушаал, гарын үсэг/

Ажлын хэсгийн удирдагч

/овог нэр, албан тушаал, гарын үсэг/

1. Бригадын бүрэлдэхүүн

№	ИТА нэрс	Албан тушаал	ХАБЭА зэрэг	Гарын үсэг
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				

2. Ажил гүйцэтгэх үед заавал мөрдөх ХАБЭА болон ГАУС арга хэмжээнүүд

1. Ажлын байрыг бүрэн бэлтгэж РМБ-ны түлхүүр авч, газардуулга хийж пайз зүүнэ.
2. ХАБЭА дүрмийн өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахиж ажиллана.
3. Хамгаалах хэрэгслийг хэрэглэхийн өмнө заавал өөрийн биеэр шалгаж ашиглаж болох эсэхийг тогтоосны дараа хэрэглэнэ.
4. Багаж сэлбэг хэрэгслийг цүнх саванд хийж найдвартай бэхэлж дээш гарна.

5. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөж дээш гарна.
6. Ажил эхлэхээс өмнө наряд авч, эрүүл мэндийн байдлаа хянуулж зөвшөөрөл авна.
7. Өндөрт ажиллаж буй ИТА нар нь зөвхөн өөрийн багийн ахлагчийн командаар ажиллах ба өөр хүний команд болон командгүй ажиллаж болохгүй.
8. Ил задгай гал гаргахгүй байж, ой хээрийн түймрээс сэргийлж ажиллана.

Ажил эхлэх хугацаа 20..... он сарын өдөр цаг минут

3. Хийгдэх ажил

№	Хийх ажил	Гүйцэтгэл

4. Эрүүл мэндийн дүгнэлт

№	ИТА нэрс	Албан тушаал	Үзлэгийн дүн <i>/цусны даралт/</i>	Зааварчилгаа авсан
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				

Ажилд гарахад ХАБЭА зааварчилгаа өгсөн инженер


/...../

Ажил дуусах хугацаа 20..... он сарын өдөр цаг минут

5. Ажил дуусгах

Ажил гүйцэтгэсэн бригадын удирдагч	Ажлыг хүлээн авсан ээлжийн ахлагч	Наряд хаасан ахлах инженер
..... /овог нэр, албан тушаал, гарын үсэг/	 /овог нэр, албан тушаал, гарын үсэг/	 /овог нэр, албан тушаал, гарын үсэг/

20..... он сарын өдөр цаг минут



“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-н
2023 оны 12 дугаар сарын 14 өдрийн
159 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ НАРЯД

№ 001-0520

20... оны сарын.....өдөр

Аймаг, хот, сум, нэгжийн нэр

Наряд олгосон:

/овог нэр, албан тушаал

Ажил хийж гүйцэтгэх ИТА

/овог нэр, албан тушаал, гарын үсэг/

1. Бригадын бүрэлдэхүүн /ажил гүйцэтгэх үед хамтран ажиллах ИТА бүртгэл/

№	ИТА нэрс	Албан тушаал	Эрүүл мэндийн дүгнэлт	ХАБЭА зэрэг	Гарын үсэг

Ажил хийж гүйцэтгэх зөвшөөрөл олгосон

Тухайн нэгжийн оператор

/овог нэр, албан тушаал, гарын үсэг/

2. Ажил гүйцэтгэх үед заавал мөрдөх ХАБЭА болон ГАУС арга хэмжээнүүд

2.1 Цаг агаарын онц аюултай үзэгдлээс сэрэмжлэх мэдээг байнга сонсож засвар үйлчилгээний ажилд томилолтоор явах ажилтнуудын хувийн бэлтгэлийг /цаг агаарын нөхцөлд таарсан гутал, хувцас, ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл /хангуулан, машин унааг явах газар орны нөхцөлд тохируулан сонгож бэлдүүлнэ.

2.2 Эрсдэлд орж болзошгүй нөхцөл байдал үүссэн, зам эвдэрсэн, гулгаа үүссэн уулын оройд байрлах станцад гарах боломжгүй үед автомашиныг зогсоож явган явж очих болон өөр эрсдэл багатай тойруу зам сонгох зэрэг эрсдэлээс сэргийлнэ.

2.3 Техник хэрэгсэлд хэмжилт шалгалт хийх, ашиглахын өмнө тухайн төхөөрөмжийн техникийн баримт бичигтэй танилцаж ажиллагааны онцлог, аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагуудыг мэдэж, бүрэн хангасан байна. Төхөөрөмжид үзлэг үйлчилгээ хийх зөвшөөрөлгүй хүн хүрч ажиллахыг хориглоно.

2.4 Техник хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдах, ашиглалтын аюулгүй ажиллагааны шаардлага зөрчигдсөн тухай бүр удирдлагадаа мэдэгдэж хэвийн болгох үүрэгтэй.

2.5 Тамхи татах, ил гал гаргах, зориулалтын бус цахилгаан хэрэгсэл ашиглахыг хориглоно.

2.6 Ажил эхлэхийн өмнө хэддүгээр хэсэгт антенныг хэрхэн яаж бэхлэх болон хүн хүчийг хэрхэн хуваарилах талаар нэгдсэн ойлголт өгч хүн бүрийн гүйцэтгэх үүрэг тодорхой байна.

2.7 Ажил хийгдэх үеийн цаг агаарын нөхцөлийг харгалзах ба салхины хурд 12м/сек-ээс их байх, бороо цас орсон, мөстөлт үүссэн, их манантай нөхцөлд антенны цамхагт ажиллахыг хориглоно.

2.8 Цамхагт ажиллах үед хэрэглэх багаж материалууд нь тусгаарлалт сайтай, шалгагдсан байх ба гагнуурын аппарат болон алх хэрэглэж байгаа үед тэдгээрийн их бие заавал газардуулагдсан байна. Багажийг тусгай саванд хадгална.

2.9 Цамхагт хүн ажиллаж байхад түүний ойр орчимд түүний өндрийн гуравны нэгтэй тэнцэх тойрог доторх зайг аюултай бүсэд оруулж тооцно

Ажил эхлэх хугацаа 20..... он сарын өдөр цаг минут

3. Хийгдэх ажил


№	Хийх ажил	Гүйцэтгэл

Ажил дуусах хугацаа 20..... он сарын өдөр цаг минут

4. Ажил дуусгах

Ажил гүйцэтгэсэн	Наряд хаасан /Тухайн нэгжийн оператор/
..... /овог нэр, албан тушаал, гарын үсэг/	 /овог нэр, албан тушаал, гарын үсэг/

5. Уг наряд нь удирдамжийн хамт хүчин төгөлдөр болно.



Хамгаалалтын хувцас хэрэгсэл шалгах хуудас

20...он сарын ...өдөр

№	Жагсаалт	Бүрэн бүтэн байдал	тайлбар
1	Малгай		
2	Хувцас		
3	Бээлий		
4	Дөрөө		
5	Өндрийн бүс		
6	Татлага олс		
7	Бусад /туслах, нэмэлт хэрэгсэл/		

Хүлээлгэн өгсөн:

/Албан тушаал/

Хүлээн авсан:

/Албан тушаал/